



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

### Г Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.2, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Бүгд найрамдах Солонгос улс дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн нийт 83,247,040.57 (наян гурван сая хоёр зуун дөчин долоон мянга дөчин төгрөг тавин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 40,600,000.00 (дөчин сая зургаан зуун мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоож, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Автомашиньг автотээврийн улсын бүртгэлд бүртгүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

13300051/  
8-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2025 оны 04 дүгээр сарын 03 ны өдрийн  
134 дүгээр тогтоолын хавсралт

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ,  
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| д/д      | Автомашины нэр, марк,<br>арлын дугаар               | Ашиглалтад<br>орсон он | Тоо<br>хэмжээ | Балансын үнэ,<br>хуримтлагдсан<br>элэгдэл<br>(төгрөг)                                         | Шинэчлэн<br>тогтоох нийт<br>үнэ (төгрөг) | Цаашид<br>ашиглах<br>жил | Шилжүүлэн хүлээн авах<br>байгууллага                  |
|----------|-----------------------------------------------------|------------------------|---------------|-----------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------|--------------------------|-------------------------------------------------------|
| 1        | Гранд Старекс, арлын<br>дугаар<br>KMJWA37KBFU662215 | 2014                   | 1             | 49,939,491.95                                                                                 | 21,000,000.00                            | 4                        | Хүүхэд, гэр бүлийн хөгжил<br>хамгааллын ерөнхий газар |
| 2        | Гранд Старекс, арлын<br>дугаар<br>KMJWA37KBEU571494 | 2011                   | 1             | 33,307,548.62                                                                                 | 19,600,000.00                            | 4                        | Хүүхдийн тусламжийн 108<br>утасны үйлчилгээний төв    |
| Нийт дүн |                                                     |                        |               | 83,247,040.57                                                                                 | 40,600,000.00                            |                          |                                                       |
|          |                                                     |                        |               | (наян гурван сая<br>хоёр зуун дөчин<br>долоон мянга<br>дөчин төгрөг<br>тавин долоон<br>мөнгө) | (дөчин сая<br>зургаан зуун<br>мянга)     |                          |                                                       |